

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

**МОНГОЛЫН АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗҮҮДИЙН ҮҮСЭЛ,
ТӨЛӨВШЛИЙН ЯВЦ, ҮЕЧЛЭЛИЙН ОНЦЛОГ**

Т.Өнөрсайхан*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, сэтгүүл зүйн магистр, докторант

Түлхүүр үг: арилжааны телевиз, контент, үечлэл, өргөн нэвтрүүлэг, суваг телевиз

“Халуун нь яваад хүйтэн нь ирнэ” гэж Канадын онолч Маршалл Маклюен 1964 онд гаргасан “Хэвлэл мэдээллийг ойлгох нь”¹ номдоо бичжээ. Тэр үед хүмүүс хар цагаан дэлгэцэн дээр бүдэгхэн жирэлзэн анивчих дүрсийг үзэхдээ мэдээллийг орхигдуулахгүйн тулд маш их анхаарал төвлөрүүлэх шаардлагатай байж. Ийм дүрсийг бүрэн болгож гүйцээхэд хүн өөрөө идэвхтэй оролцох ёстой болдог учраас телевизийг хүйтэн гэжээ. Энэ хүйтэн мэдээллийг үзэгчид өөрсдийн оролцоогоор халаадаг гэж тэрээр тайлбарласан байна. Харин хүлээн авагчдад тал бүрийн бэлэн мэдээлэл өгдөг учраас тогтмол хэвлэл халуун юм гэжээ. Телевизийн хувьд дүрс ямар чухал хийгээд ер нь дүрс өгүүлэмжтэй, үнэмшилтэй, утга учиртай гэдгийг тодотгож, цаашилбал олон хүнийг татах телевизийн нууц нь дүрсэнд оршино, харилцаа холбооны шинэ технологи нийгэмд шинэ журмыг бий

болгож, шинэ соёлыг үүсгэнэ. Даяарчлагдсан тосгоны онол хэвлэл мэдээллээр дамжин хэрэгжинэ гэж Маклюен нотолсон байдаг.

50 гаруй жилийн өмнөх энэ таамаглал телевизийн ирээдүйг зөгнөсөн үг байлаа. Дуу авиаг дамжуулж болдгийг мэдсэнээр радио бий болсонтой адил дүрсийг орон зайд түгээдэг техник хэрэгсэл зохион бүтээснээр телевиз үүссэн түүхтэй. Телевиз хүмүүсийн өдөр тутмын амьдралд нэвтэрснээр оюун санаа, нийгмийн хандлага, зан араншин, амьдралын хэв маягт төдийгүй дэлхий нийтийг хамарсан даяаршлын явцад ч онцлог байдлаараа өөрийн нөлөөг оруулсан билээ.

Харин ХХ зууны хамгийн нөлөөтэй хүчирхэг мэдээллийн хэрэгсэл болох телевиз манай оронд нилээн хожуу үүссэн юм. Телевиз юуны түрүүнд тухайн орны шинжлэх ухаан, техникийн хөгжлийн түвшинтэй холбоотой байдаг. Олон түмэнд хүртээмжтэй телевизийн суваг байхын тулд нийт нутгийг хамарсан өөрийн суваг, сүлжээтэй байх нь нэн тэргүүний шаардлага юм. Нөгөө талаар, их хэмжээний зардал, олон төрлийн мэргэжлийн боловсон

хүчин шаарддаг учраас улс орон эдийн засгийн хувьд боломжтой байх учиртай. Хэдийгээр телевиз байгуулах нийгмийн захиалга, хэрэгцээ шаардлагатай байсан боловч дээрх асуудлуудаас шалтгаалж хойш татагдсаар, манайд телевизийн түүх 1967 оноос бичигдэж эхэлсэн билээ.

Монгол телевиз байгуулагдсанаар ОНМХ-ийн систем бүрэлдэн тогтож, телевизийн сэтгүүл зүйн эхлэл тавигдсан гэж үздэг. Гэхдээ бүтэн салбар болон өргөжихөд дахин 20 гаруй жил шаардагдсан юм.

1990-ээд оноос өмнө Монголд үндэсний хэмжээний телевизээс гадна орон нутгийн телевизүүд үйл ажиллагаа явуулж байсан нь салбар бүрэлдэх анхны хэлбэр байсан гэж үзэх нь бий. Хэрэв “телевиз”-ийн мөн чанарын хүрээнд Чойбалсан, Сайншанд, Эрдэнэт зэрэг төвлөрсөн сууринд байсан “орон нутгийн телевиз”-үүдийн онцлогийг харгалзвал тэднийг бүрэн төгс телевиз гэж нэрлэх нь учир дутагдалтай. Тэдгээр нь ихэнхдээ өргөн нэвтрүүлгийг хүлээн авч, дахин дамжуулах чиглэлээр ажилладаг байв.

Телевизийн систем бүрэлдэн тогтох эхний алхмыг Монгол телевизээс цаг аван контентоо цацаж байсан хувийн студиуд хийсэн юм.

Анхны хараат бус телевиз болох “Чөлөөт телевиз” 1992 оны дөрөвдүгээр сарын 25-нд, “Мэдээлэл арилжааны чөлөөт суваг” 1992 оны тавдугаар сарын 25-нд анхны нэвтрүүлгээ үзүүлжээ². Өөрийн тусгай суваг байгаагүй учир Монголын үндэсний телевизээс эфирийн цаг авч цацаж байв. Тухайн үед сэтгүүлч, уран

бүтээлчдийн цалин хөлс тогтмол, нийтлэлийн урамшуулал бага, мөн чөлөөтөөр сэтгэж, уран бүтээл хийх гэсэн хүсэл нь “телевиз”-студийн хэлбэрээр ажиллах шалтгаан, нөхцөл болсон гэж үзэж болно. Мөн 1991 онд “Аж ахуйн нэгжийн тухай” хууль батлагдсан нь телевизийн ажилтнуудыг хийж буй уран бүтээлээ оюуны бизнес болгох боломжийг бүрдүүлсэн. Студийн хэлбэрээр буюу тухайн үед хуулийн этгээдийн гэрчилгээ авч Монголын үндэсний телевизэд ажиллаж байсан олон уран бүтээлч хувиараа нэвтрүүлэг бэлдэх болсон билээ. Энэ бүхний ололттой тал нь телевизийг мэдээлэл, суртал ухуулгын хэрэгсэл төдийгүй арилжааны зориулалтаар ашиглаж болохыг батлан харуулсан явдал байлаа.

Тухайлбал, Монголын мэдээлэл дамжуулах “Эм-Би-Си”, “Монголын чөлөөт телевиз”, “Зохиогчийн телевиз”, “Жолоо”, “Худалдаа арилжааны чөлөөт суваг”, “Тэнхлэг”, “Тулах цэг”, “Капитал” зэрэг телестуди Хууль зүйн яаманд бүртгүүлж, аж ахуйн нэгжийн гэрчилгээ авсан байна. Эдгээр телевизүүд өөрийн бие даасан суваггүй байсан учраас “Монгол” телевизээс эфирийн цаг авч нэвтрүүлсэн байдаг. 1992 оны 4 дүгээр сарын 25-нд Ц.Төрмандах захиралтай “Чөлөөт телевиз”-ийн нэвтрүүлэг, 1992 оны 5 дугаар 25-нд Д.Гарам-Очир захиралтай “Мэдээлэл арилжааны чөлөөт суваг, 1992 оны 6 дугаар сарын 6-нд “Жолоо” зохиогчийн телевизийн анхны хөтөлбөр Монгол телевизийн эфирээр цацагдсан байдаг³.

Монголд телевиз салбар болж бүрэлдэн тогтоход анхны алхам

болсон эдгээр «“олон телевиз” үүсч гараад төдөлгүй сураг ажиг тасарсан билээ»⁴. Телевизийн бие даасан суваг байгаагүй, Монголын үндэсний телевизээс хязгаарлагдмал эфирийн цаг авч цацаж байсан, зар сурталчилгаанаас олох ашиг тогтмол бус, тоног төхөөрөмж, хүн хүчний боломж тааруу байсан зэрэг олон шалтгаан үйл ажиллагаагаа зогсооход хүргэжээ.

1992-1995 оны хоорондох энэ зурвас үеийг телевизийн арилжааны хэлбэр байж болохыг баталсан үзэгдэл гэж тодорхойлж болно. Хэдийгээр өөрсдийгөө “телевиз” гэж нэрлэж байсан боловч бие даасан өөрийн суваг байгаагүй, нэвтрүүлгээ бэлдэн үндэсний ганц телевизээс цаг аван цацаж байсан нь бие даасан телевизийн хэмжээнд авч үзэхэд түвэгтэй юм. Гэхдээ арилжааны телевизүүдийн эхлэл буюу анхны хэв маягийг Монголын телевизийн сэтгүүл зүйд тавьсан чухал явдал байлаа.

Монголд телевизийн систем бүрэлдэн тогтсон үе, арилжааны телевизийн үүслийн явцыг 1996-2011 оныг хүртэл 15 жилд хамааруулж үзэж болох юм. Тухайн үеийн Монгол телевиз энэ системийг бүрэлдэн тогтох эх үндэс суурь байсан гэдэгтэй маргах аргагүй. Анхны хараат бус телевизүүд байгуулагдсанаар телевизийн систем бүхэлдээ бүрэлдэн тогтож, өмчийн

шинэ хэлбэрүүд үүссэн. Улсын өргөн нэвтрүүлгийн телевизээс олон нийтийн өргөн нэвтрүүлэг, арилжааны телевизүүд бий болсон билээ. Телевизийн системийг бүрдүүлэгч хэсгүүдийн энэ үеийн онцлогийг гаргахын тулд дараах байдлаар бүлэглэн үзэж болно.

1. *Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөгжлийн явц.* “MN 25 суваг” манай орны анхны хувийн чөлөөт телевиз юм. 1996 оны есдүгээр сарын 27-нд анхны нэвтрүүлгээ албан ёсоор цацсан тус

телевиз өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан “телевиз”-үүдээс ялгарах онцлог нь энэ төрлийн байгууллагын хэв шинжийг агуулсан хэд хэдэн редакцийн бүтэцтэй, хөтөлбөртэй, өөрийн цацах сувагтай байв. Төрийн өмчид суурилагагүй, хэсэг хөрөнгө оруулагчдын нэгдэл

дээр байгуулагдсан арилжааны сувгийн ерөнхий дүр төрхийг илэрхийлсэн телевиз байлаа. Хөтөлбөрийн бүтцийн хувьд санхүүжилт олох олон улсын арилжааны телевизүүдийн аргыг ашиглаж, хөгжөөнт цэнгээнт болон төрөл бүрийн арилжааны агуулгуудыг цацаж байв. Холимог хэлбэрийн хөтөлбөр болох инфомершиалын анхдагч хэлбэрүүд хийгдэж эхэлсэн нь “MN25” сувагтай холбоотой. Энэ нь Монголын телевизийн хөгжилд бизнесийн нэвтрүүлэг байж болох, түүний олон арга хэлбэрийг харуулсан эхний алхам байлаа.



1992-1995 оны үеийг телевизийн арилжааны хэлбэр байж болохыг баталсан үзэгдэл гэж үзэж болно. Хэдийгээр өөрсдийгөө “телевиз” гэж нэрлэж байсан боловч бие даасан өөрийн суваггүй, нэвтрүүлгээ бэлдэн үндэсний ганц телевизээс цаг аван цацаж байсан нь бие даасан телевизийн хэмжээнд авч үзэхэд түвэгтэй юм



1996 оны дөрөвдүгээр сарын 15-нд Америкийн ашгийн бус боловсролын байгууллага болох “ЭМОН” сангийн харьяанд “Ийгл бродкастинг” компани “Ийгл” телевизийг үүсгэн байгуулсан юм. “Телевиз байгуулсан гол зорилго нь Монголын олон нийтэд ортодокс, эвангел Христ итгэлийн түүх, мөн чанарыг таниулах, боловсрол олгох, түүнчлэн үг хэлэх, хэвлэн нийтлэх, сэтгэн бодох эрх чөлөөг телевизэд нэвтрүүлэх замаар Монголын эрх чөлөө, ардчиллын хөгжлийг дэмжих явдал” байжээ⁵. “Ийгл” телевиз байгуулагдсан явдал Монголын сэтгүүл зүйд шинэ арга барил болох Америкийн сэтгүүл зүйн мэдээ материалыг сонгож, эрж хайж, боловсруулж, түгээх аргыг нэвтрүүлэхэд чухал түлхэц болсон юм. Тус телевизийнхэн Монгол үзэгчдийн мэдээллийн эрэлт, хэрэгцээнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүйн шинэ ертөнцийг авчрах” зорилтыг нийтлэлийнхээ бодлогын цөм болгон дэвшүүлж байв.

Телевиз бүх агуулгыг гаргадаг, бүхнийг үзүүлдэг гэсэн тухайн нийгмийн ойлголтыг эвдэж, төрөлжсөн суваг байж болдог, үйл ажиллагаа нь ямар зарчмаар явж болохыг анхлан харуулсан давуу талтай юм. Телевизийн үүргийн давамгайлал арилжааны сувгуудад хэрхэн илэрдгийн илэрхийлэл болж, мэдээлэх, нэгтгэх үүрэг “Ийгл” телевизийн гол зорилгыг тодорхойлж байв. Ингэснээр Монголын телевизийн системд цоо шинэ хэлбэрийг нэвтрүүлж, клерикал буюу шашны сэтгүүл зүйн хөгжлийн суурийг тавьснаараа онцлог үйл явдал байлаа.

1992 онд “Телекино” үйлдвэрийн суурин дээр байгуулагдан, Монголын үндэсний телевизээс эфирийн цаг авч, нэвтрүүлгээ цацаж байсан “Улаанбаатар” телевиз 1998 онд өөрийн гэсэн сувагтай болсноор телевизийн хэв шинжийг олсон юм. Хэдийгээр үүнээс зургаан жилийн өмнө нэвтрүүлгээ цацаж, өглөөний хөтөлбөр бэлтгэн, анхны олон ангит киног хийж байсан боловч телевизийн хэмжээнд авч үзэхэд хангалтгүй. ОНМХ-ийн онцлогийг хэрэгсэл болох дамжуулах суваг нь тодотгодог. Тиймээс “Улаанбаатар” телевизийн үйл ажиллагааг 1992 оноос тооцож болох ч бие даасан телевизийн хэмжээнд 1998 оноос ажиллаж эхэлсэн гэж үзэх үндэслэлтэй билээ. Нэвтрүүлгээ зөвхөн нийслэлд үзүүлдэг байсан «тус телевиз 1998 онд гарсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай”⁶ хуулиар хувьчлагдах ёстой байсан хэдий ч 2005 оныг хүртэл Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын харьяанд орон нутгийн төр засгийн телевизийн статустай ажиллаж байв»⁷. “Улаанбаатар” телевиз ижил үед байгуулагдсан бусад телевизүүдээс ялгарч, тогтмол үйл ажиллагаа явуулах болсон нь дараах учир шалтгаантай. “Телекино” үйлдвэрийн суурин дээр байгуулагдсан нь техник технологийн үндэс суурь болсон, санхүүгийн хувьд Нийслэлийн захиргаатай холбоотой байсан нь цаашид үйл ажиллагаа нь жигдрэхэд чухал нөлөө үзүүлсэн юм.

Цахим хэрэгслийг уламжлалт мэдээллийн хэрэгсэлтэй холбон, өнөөгийн Интернет телевизийн анхны алхмыг хийсэн үйл явдал 2003 онд болж, “ТВ5” телевиз байгуулагдав.

Цаашид зах зээлд телевизийн олон хэлбэр үүсч, тоон өсөлт илэрхий ажиглагдаж эхэлсэн нь телевизүүдийг өөрийн онцлог шинжээр ялгаран гарах шаардлагыг аяндаа бий болгосон юм. “ТВ5” телевиз тухайн үед Монголд хүчээ авч байсан Интернетийн орон зайг ашиглаж, гадаад оронд суугаа монголчууддаа мэдээллийг шууд хүргэх зорилгоор Интернет телевизийн анхны хувилбарыг нэвтрүүлсэн. Цахим хуудсаараа дамжуулж мэдээллийн шинэ хэрэгслүүдийн нийлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээрээ онцлогтой байв.

2003 оны есдүгээр сард Монголын телевизийн салбарт 24 цагийн эфирээр ажиллаж болохыг харуулсан “ТВ9” телевиз үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. “Eagle” телевизтэй нэгэн адил шашны сэтгүүл зүйг төрөлжин хөгжихөд хувь нэмрээ оруулсан юм.

Энэ үеэс телевизүүдийн үзэгчдийг хуваах, зар сурталчилгааны зах зээлийн өрсөлдөөн хүчтэй ажиглагдаж эхэлсэн байдаг. “MYTB”, “UBS”, “25-p суваг”, “Eagle”, “ТВ5”, “ТВ9” гэсэн өргөн нэвтрүүлгийн үндсэн телевизүүд хүн ам төвлөрсөн нийслэлийн зар сурталчилгааны зах зээлийг хувааж, мэдээ мэдээлэл, агуулгын хувьд өрсөлдөх байдал бий болсон. Тухайлбал, Монголын үндэсний телевиз 1981 оны Зуны олимпийн наадмыг Оросын телевизийн дэмжлэгтэйгээр Москва хотоос, 1990 оны Азийн зуны спортын 11-р наадмын нээлтийн ёслолын ажиллагааг Бээжин хотоос шууд дамжуулсан тухай баримт бий. Тогтвортой бус энэ дамжуулалтыг байнгын болгож, телевиз өөрийн мөн чанарыг өмчийн аль ч хэлбэрт орсон

алдадгүйг “ТВ5” телевиз баталсан. Ази, Номхон далайн өргөн нэвтрүүлгийн холбооны гишүүнд олгодог эрхийн дагуу Афиний зуны 28-р олимпийн наадмыг эхнээс нь дуустал шууд дамжуулах эрх худалдан авч, эх хэлний тайлбартайгаар хүргэсэн юм. Олимпизмийг дэмжихийг уриалж, спортын амжилт үзүүлсэн хүүхдүүдийг урамшуулах, тэднийг сурталчлах, спорт клубуудын үйл ажиллагааг олонд таниулах сурвалжлагуудыг давхар хийж байв. Монголын телевизийн салбарт контентын албан ёсны худалдааг нэвтрүүлж, мөн кросс-маркетингийн аргыг хэрэгжүүлсэн анхны алхам байлаа.

Монгол Улсад телевизийн систем бүрэлдэн тогтоход нөлөө үзүүлсэн бас нэг үйл явдал 2005 онд болсон нь Төрийн мэдлийн телевизийг нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан өрсөлдөх чадварыг нь сайжруулах, санхүүгийн шинэ боломжууд бий болгох, үзэгчийн хүрээг тэлэх зэрэг нийгмийн захиалгаар олон нийтийн телевиз байгуулах асуудал яригдаж эхэлсэн нь бодит ажил болж, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсан билээ. Ингэснээр төрөөс хараат эрх баригчдын үзэл бодлын шууд индэр байсан Монголын үндэсний телевизийн статусыг өөрчилж, Олон нийтийнх болгосон юм. Тухайн үед үзэгчийн хураамжийн 4-5 хувийг авдаг байсан арилжааны сувгуудын энэ эрхийг хааж, зөвхөн олон нийтийн телевизэд олгохоор болсон, эргээд тус телевизийн зар сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг хоёр хувиар хязгаарласан нь зах зээлийн шударга өрсөлдөөний зарчмыг

олон улсын жишгээр тогтоосон шийдвэр байлаа. Санхүүжилтийн эх үүсвэрийн дээрх хуваарилалт нь өмчийн хэлбэрийн онцлогийг бүр тодотгож, энэ нь агуулгын сонголтонд шууд нөлөөлөх хэрэгсэл болсон.

Харин олон нийтийн телевизэд төрөөс санхүүжилт өгч, төсөвт зардлыг нь суулгадаг байдлыг өөрчлөөгүй юм. Энэ нь дэлхий нийт дэх олон нийтийн телевизийн санхүүжилтийн жишгийг зөрчсөн, тус телевизийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлсөн шийдвэр байв. Өөрөөр хэлбэл, телевизийн салбарын цэвэр өрсөлдөөнд төр оролцож, монополь байдлыг далд байдлаар дэмжсэн хэлбэр юм.

Ингэснээр арилжааны телевизүүдийн зар сурталчилгааны зах зээлийн шууд өрсөлдөгч, хуваагч биш болж, агуулга сонголтоор ч өмчийн энэ хоёр хэлбэр хоорондоо өрсөлдөх шаардлагагүй болсон. Өөр өөрийн өвөрмөц онцлогийг бүрдүүлсэн агуулгын сонголт, үзэгчийн хүрээг бий болгох боломж бүрдсэн билээ.

2006 оныг арилжааны өргөн нэвтрүүлгийн телевизийн “бум” буюу тооны тэсрэлтийн үе гэж нэрлэдэг. “2004 онд 37, 2009 онд 82... болж өсчээ”⁸. Жил бүр 7-20 хүртэл тооны телевиз шинээр байгуулагдаж байв. Ялангуяа сонгуультай жилүүдэд энэ тоо огцом өсч 2008 онд 11, 2012 онд 19 телевиз байгуулагджээ. Зөвхөн Улаанбаатарт төвтэй өргөн нэвтрүүлгийн 17 телевиз бүртгэлтэй байдгаас 12 нь 2006-2011 онд шинээр нээгдсэн байна. Энэ үеэс телевизийн зах зээлийн өрсөлдөөн тооны хувьд ханаж, бие бие-нээсээ ялгарч гарах гэсэн оролдлого нь технологийн хөгжил болж эхэлсэн.

Телевизүүдийн контентын өрсөлдөөн технологийн чиг хандлагад тулгуурлаж байсан 2003 оны үзэгдэл энэ үеэс улам хүчээ авч 2006 оны наймдугаар сараас байнгын эфирээ цацаж эхэлсэн “SBN” телевиз хальсгүй технологийг анх нэвтрүүлэв. Дуу дүрсний өндөр үзүүлэлтээр дүрслэлийн урлагийн онцлогийг гаргаж шинэ технологи нэвтрүүлсэн нь өрсөлдөөний шинэ хандлагыг бий болгосон. Энэ өрсөлдөөнд хамгийн сүүлийн үеийн технологи нэвтрүүлж, 2012 оноос телевиз үзэлтийн судалгаанд байнга тэргүүлэх байруудыг эзлэх болсон “Монгол” HD телевиз онцгой байр эзэлнэ. 2009 оны есдүгээр сараас албан ёсны эфирээ цацаж эхэлсэн “Монгол” HD манайд анхны HD формат (High definition – өндөр нягтрал) нэвтрүүлсэн телевиз юм.

“Ийгл” телевизийн дараа арилжааны өргөн нэвтрүүлгийн телевиз нэг чиглэлээр дагнаж болдгийг баталж, “Медиа групп”-ийн “NTV” буюу “New Television” 2006 оны 11 дүгээр сарын нэгнээс Улаанбаатар хотод туршилтын эфирээ цацаж эхэлсэн. Телевиз зөвхөн нэг чиглэлээр илүүтэй дагнаж болдгийг харуулах зорилготой анхны энтертейнмент телевиз болсноороо онцлогтой юм. Энэ үеэс сэтгүүл зүйн хөгжилд нөлөөлж буй конгломерацийн үзэгдэл телевиз төвтэйгээр ажиглагдах болсон билээ.

2. Суваг телевизийн хөгжлийн явц

1995 онд олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч “Сансар” кабелийн суваг байгуулагдсанаар суваг телевизийн хөгжлийн эхлэл тавигдсан юм. Эхэн үедээ олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд монгол хэл дээрх

телевиз цөөн байсан учраас гадны сувгуудыг үзүүлдэг байв. Удалгүй “Хийморь”, 1998 онд “Supervision” зэрэг олон сувгийн дамжуулах үйлчилгээний компани байгуулагдсанаар нийслэлийн хэмжээнд өрсөлдөх сувгууд бий болжээ. Суваг телевизийн хөгжлийн явц дамжуулагч үйлчилгээ эрхлэгчтэй шууд холбоотой. Анхлан үндэсний 2-3 телевизээс өөр цацах суваггүй байсан учраас монгол хэл дээрх сувгийнхаа тоог нэмж, үзэгчдээ татахын тулд өөрсдөө үйлдвэрлэгч болсон байдаг. “Сансар” кабель “STV” гэсэн ерөнхий нэрийн дор “STV-1” өдөр бүрийн нэвтрүүлэг, “STV-2” хөгжим, зар сурталчилгаа, “STV-3” хүүхэлдэйн киноны сувгуудыг тус тус байгуулжээ. Мөн парламентын, танин мэдэхүйн, хөгжмийн гэх зэргээр сувгийнхаа төрлийг нэмсэн байна. Олон улсын жишигт дамжуулагч компани үйлчлүүлэгч телевизүүдтэйгээ ижил үйлдвэрлэгч байхыг хориглодог. Тухайн үед эх хэл дээрх телевизийн тоо бага, төрөлжсөн сувгууд бараг байгаагүй зэрэг нь үйлдвэрлэгч-дамжуулагчийн үүргийг хамсатгахад хүргэжээ. Суваг телевизүүд өөрийн үндсэн онцлогоор үйл ажиллагаа явуултал дахин 10 гаруй жил шаардагдсан юм.

2007 оноос суваг телевизүүд олноор байгуулагдаж эхэлсэн. Тухайн үедээ суваг телевизийн зөвшөөрөл олгохдоо төрөлжсөн чиглэлээр өгч байсан боловч ихэнх нь өргөн нэвтрүүлгийн нэгэн адил хүссэн контентоо цацаж байв. Бие даасан суваг телевизээс гадна өргөн нэвтрүүлгийн дөрвөн телевизэд суваг телевизийн зөвшөөрөл давхар олгосон нь дээрх давхцалыг улам бүр бататгасан юм.

Тухайн үед эдгээр телевизүүдэд тавих хяналт шалгалт дутмаг байсан нь үйл ажиллагааны задгайралд хүргэж, төрөл бүрийн зохисгүй контент явуулах (насанд хүрэгчдийн контент оргил цагаар гаргах, ТВ-чат, ТВ-тоглоом), зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэхгүй байх (2011 оны байдлаар суваг телевизүүд төрөлжсөн хэлбэрээр бус өргөн нэвтрүүлгийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байв), нэг хүн, аж ахуйн нэгжид хэт олон сувгийн зөвшөөрөл төвлөрөх зэрэг дутагдал гарч байв.

Суваг телевиз, өргөн нэвтрүүлгийн телевизийн ялгаа байхгүй болж телевизийн зах зээлд “хэн юу дуртайгаа үзүүлж, хийж болдог” зохисгүй нөхцөл байдал энэ үед үүссэн юм. Зөвхөн агуулгын хувьд, нэвтрэх онцлогийн тухайд төдийгүй, огт зөвшөөрөлгүйгээр суваг эзэмшиж телевизийн үйл ажиллагаа явуулж байсан дутагдлууд ч гарсан билээ. Гэхдээ энэ үед суваг телевизүүдийн хөгжилд чухал хэд хэдэн алхам хийгдсэн байдаг. Хил дамнасан телевизийн сэтгүүл зүйг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан, 100 хувь гадны хөрөнгө оруулалттай “Аист Монголия” суваг байгуулагдаж, 2007 оны нэгдүгээр сараас эфирээ цацаж эхэлсэн. Мөн 2012 оноос үндэстэн дамнасан мэдээллийн корпораци “Bloomberg Media Group” Худалдаа хөгжлийн банктэй хамтран “Bloomberg TV Mongolia” суваг телевизийн үйл ажиллагааг явуулах болсон юм. Глобал сувгуудын салбар үндэсний телевизүүдтэй өрсөлдөн орж ирсэн, синдикат телевизийн эх суурь тавигдсан давхар ач холбогдолтой үйл явдал байлаа.

2011 онд “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий шаардлага”-ыг Харилцаа холбооны зохицуулах хороо баталсан юм. 2015 онд дахин шинэчлэгдсэн энэхүү ерөнхий шаардлага батлагдахаас өмнө Монголын телевизийн салбарт мэргэжлийн онцлогийг тусгасан хууль эрх зүйн баримт бичиг, журам байсангүй. Тиймээс мэргэжлийн үйл ажиллагаанд шаардлага тавих боломжгүй байв. Хэт задгайрсан телевизийн салбарыг хэм хэмжээтэй болгох, цэвэр өрсөлдөөнөөр дамжуулан хөндлөнгийн хяналт тогтоох, бүрэлдээд удаагүй телевизүүдэд цаашдын үйл ажиллагааны чиг хандлагыг нь төлөвшүүлэхэд дээрх ерөнхий шаардлага чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Арилжааны телевизүүдийн төлөвшлийн үеийг “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий шаардлага”-ас салгаж ойлгох аргагүй юм.

Тус шаардлагын дагуу 2013 онд мэргэжлийн шаардлага хангаагүй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан есөн суваг телевизийг хаажээ. 2011 оноос зөрчилтэй телевизүүдэд шаардлага хүргүүлж, сануулга өгч байсан боловч шууд хааж байсан удаагүй учир анхны тохиолдол болсон юм. Үзэгчдийн гомдол санал, бусад үзүүлэлтүүдийг харгалзан эрүүл бус өрсөлдөөнийг цэгцлэх зорилгоор тухайн үед ийм шийдвэр гаргажээ. Мөн ондоо телевизийн эрх олгохыг түр зогсоосон байдаг. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын зүгээс хэвлэлийн эрх чөлөөг боомилсон шийдвэр гэж эсэргүүцэж байсан боловч бодит байдлыг дүгнэж үзэхэд сэтгүүлчийн бүтээл

болон редакцийн бодлогод нөлөөлсөн зүйлгүй, гагцхүү телевизийн мэргэжлийн үйл ажиллагаа, хэм хэмжээг тогтоох гэсэн анхны сануулга байсан юм. Телевизүүдийн үйл ажиллагаа цэгцрэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Олон улсын телевизийн салбартай харьцуулвал манайд арилжааны телевиз бий болоод богино хугацаа өнгөрч байгаа боловч хөгжлийн хувьд харьцангуй хурдтай явж байна. Энэ нь мэдээллийн технологитой шууд холбоотой. 2015 онд “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх” үндэсний хөтөлбөр эцэслэн хэрэгжиж, шинэ форматад орон даяар шилжсэн. Бодлогын түвшинд телевизүүдийг технологийн өрсөлдөөнөөс чөлөөлсөн үйл явдал гэж хялбараар тайлбарлаж болох юм. Ингэж технологийн шийдлээр дэлхий нийтээс хоцрохгүй явж байгаа боловч энэ үеэс контент үйлдвэрлэл ард хоцорч эхэлсэн нь илт анзаарагдах болов.

Тооны хувьд зах зээлийн эрэлтээс хэт давсан телевизүүд контентын дутагдалд орж, үзэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан үндэсний бүтээл ховордсон юм. Тиймээс телевизийн хөгжлийн дараагийн үе шатыг арилжааны телевизүүдийн төлөвшлийн үе буюу контентын эрэл хайгуулын үе гэж тодорхойлж байгаа билээ.

Ийнхүү 1996 онд арилжааны анхны телевиз эфирээ цацсанаас хойш 20 жилийн хугацаанд Монголд олон улсын практикт нэвтэрсэн телевизийн төрөл бүрийн хувилбар бий болоод байна. Телевизийн хэлбэрүүдийг дараах байдлаар тодорхойлж болно.

- Чиглэлээр нь: өргөн нэвтрүүлгийн телевиз. 2016 оны хоёрдугаар улирлын байдлаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан 90

телевизийн нэг нь олон нийтийнх, арилжааны 89 телевизийн 16 нь нийслэлд, 73 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. (Бүдүүвч 1.)

Бүдүүвч 1



- Суваг телевиз. Улсын хэмжээнд зөвшөөрөлтэй 90 суваг телевиз байна. Энэ тоо байнга тогтворгүй өөрчлөгддөг. Харилцаа холбооны зохицуулах хорооны улирал тутмын шалгалтын үеэр тэнцэхгүй байх, санхүүгийн

чадамжгүй болсноос үйл ажиллагаагаа зогсоох гэсэн гол шалтгаанаар жилдээ 10 орчим суваг телевиз хаагдаж байна. Мөн 5-6 суваг телевиз шинээр нээгддэг. (Бүдүүвч 2.)

Бүдүүвч 2



Хөтөлбөрийн хэлбэрээр: бүх чиглэлийнх, төрөлжсөн.

Өргөн нэвтрүүлгийн телевизэд журмын дагуу төрөлжих шаардлага тавьдаггүй. Үйл ажиллагааны онцлогоо

тодорхойлохын тулд чиглэлээ өөрсдөө сонгодог. Харин тусгай зөвшөөрлийн дагуу суваг телевизүүд дараах байдлаар төрөлжин үйл ажиллагаа явуулж байна. (Бүдүүвч 3, хүснэгт 1.)

Бүдүүвч 3



Хүснэгт 1

Орон нутгийн суваг телевизүүдийн төрөлжилт

Аймаг / Хэлбэр	Хөгжим	Нийгэм, эдийн засаг	Кино	Мэдээ, мэдээлэл	Теле худалдаа	Түүх, соёл урлаг
1 Дархан -Уул	2	1	1			
2 Говь-Алтай				1		
3 Ховд		2				
4 Орхон					1	
5 Баян-Өлгий				2		1
6 Баянхонгор				1		
7 Өвөрхангай		1				
8 Дорноговь		1				

Монголд телевизийн олон хэлбэр бий болсноор хөгжлийн шинэ түвшинд очоод зогсохгүй нийгмийн бүх л хэсэгт өөрийн орон зай, нөлөөллийг бий болгож, олон нийтийн мэдээллийн

хэрэгслийн хүчирхэг салбарыг бүрдүүлсэн билээ. Үзэгчийн сэтгэл зүйд нөлөөлж, нийгмийн амьдралын тусгал мөн тусгагч нэг хүч болдог телевизийн салбарт өмчийн болон хэлбэрийн олон

төрөл нэвтэрсэн 20 гаруй жилийн хугацаанд нэг байгууллагаас салбар болж хөгжсөн энэ зурвас үеийг дараах байдлаар үечлэн ангилж болох юм.

- 1992-1995 он. Арилжааны телевиз байгуулагдах урьдач нөхцөл бүрдсэн үе

- 1996-2011 он Монголд телевизийн систем үүсч бүрэлдсэн үе

- 2011 оноос. Арилжааны телевизүүдийн төлөвшлийн үе буюу контент хөгжлийн үе.

Хэдийгээр манай арилжааны телевизүүд төлөвшил, контент бүтээлийн өнөөгийн нөхцөл байдлаараа 1980-1990-ээд оны эхэн үеийн Скандинавын орнуудын телевизийн хөгжлийн үетэй дүйцэх шатанд явж байгаа ч гэсэн технологийн хөгжлөөр дэлхийн чиг хандлагатай зэрэгцэж ирсэн гэдэг нь тодорхой байна. Технологид суурилсан төлөвшлийн дараагийн алхам контент үйлдвэрлэл юм.

Телевиз өмчийн аль ч хэлбэрт байсан өөрийн мөн чанараар оршоор байх болно. Агуулгын болон бүтэц, үйл ажиллагааны хэлбэрт өөрчлөлт гарах боловч мөн чанар нь өмчийн хэлбэрээс шалтгаалж өөрчлөгдөхгүй. Ямар ч тохиолдолд телевизийн болзолт байдлуудын эцсийн гол зорилгын уулзвар нь олон түмэнд үйлчлэх юм.

Ишлэл

¹ Маклюен М. 2003. Понимание медиа. М., с. 15.

² Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй үндсэн ойлголт, зөвлөмж. УБ., 15 дахь тал.

³ http://mnb.mn/s/21?type_slug=iMYOHT-ийн албан ёсны Интернет хуудас.

⁴ Эрдэнэтуяа Ю. 2004. Монголын телевизийн өчигдөр, өнөөдөр. “Сэтгүүлч ба хууль” цуврал. УБ.

⁵ Норовсүрэн Л., Зулькафиль М., Чойсамба Ч. 2013. Монголын сэтгүүл зүй - 100 жил: хамгийн, хамгийн, хамгийн. УБ., 176 дахь тал.

⁶ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. 1998. 4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох. УБ.

⁷ Норовсүрэн Л., Зулькафиль М., Чойсамба Ч. 2013. Монголын сэтгүүл зүй - 100 жил: хамгийн, хамгийн, хамгийн. УБ., 168 дахь тал.

⁸ 2014. Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр. Хэвлэлийн хүрээлэн. УБ., 49 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2016. Реклам, харилцаа, сэтгэл зүй, билэгдэл. УБ.

2. Зулькафиль М. 2016. Орчин үеийн медиа: Шинэчлэл, чиг хандлага. УБ.

3. Жадамбаа Ц. 2014. “Телевизийн шинэчлэл улсын хөгжилд” илтгэл. Телевизүүдийн чуулган. УБ.

4. Maxima media. 2014 оны телевиз үзэлтийн нэгдсэн судалгааны тайлан.

5. Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй үндсэн ойлголт, зөвлөмж. УБ.

6. Норовсүрэн Л., Зулькафиль М., Чойсамба Ч. 2013. Монголын сэтгүүл зүй - 100 жил: хамгийн, хамгийн, хамгийн. УБ.

7. 2014. Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр. Хэвлэлийн хүрээлэн. УБ.

8. Эрдэнэтуяа Ю. 2004. Монголын телевизийн өчигдөр, өнөөдөр. “Сэтгүүлч ба хууль” цуврал. УБ.

9. 1998. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. УБ.

10. http://mnb.mn/s/21?type_slug=iMYOHT-ийн албан ёсны Интернет хуудас.

11. Черных А. 2007. Мир современных медиа. М.

12. Маклюен М. 2003. Понимание медиа. М.

13. Eurodata TV worldwide. New rules, new opportunities: a potential for growth. TV year 2014.

14. Lotz Amanda D. 2007. The Television will be Revolutionized. NY.

Abstract

This paper presents a television system formation process in Mongolia. Mongolia witnessed the official airing of the broadcasting debut relatively later or on September 27, 1967. The only television which was founded with help of the Soviet Union was state-owned for the political and social reasons and all its broadcasts were available for airing only after undergoing strict censorship. Such a situation of exceeding state censorship was however removed

officially during the transition period of the 1990s. The emergence of commercial televisions has opened a totally new page in the history of the Mongolian journalism where this sector used to be represented by only channel for over 20 years long. Unlike broadcasting sectors of many other countries, Mongolian commercial televisions have a short history, nevertheless they have been developing at a relatively brisk pace which is directly connected with the development of information technology.